



## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

залгаа 3 дуган, гэхдээ хаалга нь тус тусдаа. Цогчингийнх урдаасаа, нөгөө 2 дуган нь хажуугаасаа хаалгатай. Ингээд энэ залгаа 3 дуганы араар нэг эгнээ шахуу 4, 5 дуган байсан юм. Одоо тэнд босгосон суваргыг чинь гол цогчин дуганы туурин дээр босгосон юм гэнэ лээ. Бас нэг лам өвгөн нэг суварга босгосон. Тэгшид одоо 3 суварга босгосон байх. Цогчины урд утасны мод шиг нэг өндөр багана байсан. Дээрээ бурхантай л гэдэг байсан. Ямар харагдах биш, их өндөр шон. Хийдийг нурааж устгахад тэр багана үлдсэн байсан. Энэ шонгоор яахав л гэж бодоо биз дээ.

Энхбаяр: Өөр хийд жас энэ хавьд байсан үү?

Гунгаа: Байхгүй ээ, аймгаас нааш бол байсан шүү дээ. Их жас, Үйзэн ахай ч гэж байсан. Энэ хавьдаа бол Жадамба, Тэгш хоёр л байсан.

Энхбаяр: Тэгшийн гурван суваргыг хэзээ босгосон юм бэ?

Гунгаа: Анхныхыг 4 жилийн өмнө баг сумаараа хамтарч босгосон юм. Дараачийнхыг 2 жилийн өмнө нэг өвгөн лам босгосон, би түрүүн хэлсэн. Сүүлчийнхийг ноднин нутгийн нэг айл өрх ах дүүсээрээ хамтарч босгосон юм.

Энхбаяр: Сумын төвийн шинэ хийд хэдэн онд байгуулагдсан юм бэ?

Гунгаа: Есөн жил болж байна.

Энхбаяр: Анх хэдэн ламтай хурал эхэлсэн?

Гунгаа: Хорин хэдэн ламтай хурал эхэлсэн. Одоо байхгүй ээ.

Энхбаяр: Бүгд настай лам нар байсан үү?

Гунгаа: Тэр үед 70, 80-тай л өвгөчүүд байсан. Дор нь хэдэн залуучууд байсан.

Энхбаяр: Анхны хамба нь ямар хүн байв?

Гунгаа: Хамба нь Чимэддорж гэж лам байсан. Ерэн хэд хүрч өнгөрсөн. Гэсгүй нь Даш гэж одоо амьд ерэн хэд хүрч байгаа өвгөн бий. Багачуул нь голдуу хот руу явсан. Дашчойлин, Гунгаачойлин дацангуудад хүрж байгаа.

Энхбаяр: Хэзээнээс ингээд хурал зогссон бэ?

Гунгаа: Уржнангаас хурахаа больж эзгүйрсэн. Би ганцаараа өвчтэй болсон хүн босч чадахгүй болохоор яахав дээ. Харин энэ хашаа байшин доторх юмыг энэ сумын захиргаа сайн харж хаандаг бололтой юм.

Энхбаяр: Энэ суварга ямар үчиртэй вэ?

Гунгаа: Дандиа гэдэг хүн 2, 3 жилийн өмнө босгосон юм. Тэднийнхний нэг том лам Дэлгэрийн Чойрт байж байгаад таалал болсон юм. Тэгээд босгосон юм.

Энхбаяр: Энэ хийдийн гол сахиус нь юу вэ?

Гунгаа: Гол сахиус нь Лхам, гэхдээ Жамсран, Чойжоо, Гомбо сахиусуудыг тахина.

Энхбаяр: За таньд баярлалаа.